Тус барилгын ус хангамжийн систем нь өөрийн гүний худгаас ус дулаан бэлтгэх төвд байрлуулсан W=36.0м^3-ын усан санд нөөцлөн, усан сангаас ахуйн усны 2 насосоор системийг хангаж байна. Ус дулаан бэлтгэх төвөөс ДХ-1, ДХ-1-ээс дулааны шугамтай хамт сувагт явж үндсэн барилга руу оруулдаг. ДХ-1-ээс үндсэн барилга руу явж буй сувгийн нүхээр ус шүүрч ДХ-1-т ус тогтсон байдалтай. Бохир усыг өөрийн урсгалаар нь W=40.0м^3-ын бохир усны цооногт цуглуулан бохирын машинаар соруулж, зөөж тээвэрлэн төвийн шугамд нийлүүлдэг байна. 2014 онд хийгдсэн "Гурван тэс" ХХК-д боловсруулсан Архив №58/14 дугаартай барилгын талбайн инженер геологийн судалгааны дүгнэлтэд барилгын талбайд хөрсний ус 1,8м илэрч 2,0м-т тогтсон байна гэж байгаач өмнөх "ОНИКС МАРГАД" ХХК-д хийгдсэн УХАТ-ын зураг төсөлд бохир усны шугам хоолойг хуванцар хоолойгоор төлөвлөсөн, угсралт нь мөн хуванцар хоолойгоор угсрагдсан байна. Бохир усны цооног нь угсралтын үед ус тусгаарлагч муу хийгдсэнээс шалтгаалан хөрсний ус нэвчиж бохир усны цооногийн ус амархан дүүрдэг байх магадлалтай. Иймд засварын ажлын зураг төслөөр дараах өөрчлөлтүүдийг оруулав.

ГАДНА АРИУТГАХ ТАТУУРГА:

Барилгаас гарах бохир усыг өөрийн урсгалаар нь зурагт төлөвлөсөн трассын дагууд нь Ф160мм-ийн ширмэн хоолойгоор одоо байгаа цооногт холбохоор зурагт тусгав. БУХ-3-аас цооног хүртлэх авто зогсоол доогуур явж байгаа шугам хоолойд хамгаалалтын гэр хоолойг ГОСТ10704-91 стандартад нийцсэн ган хоолойгоор хийнэ. Ган гэр хоолойн гадна дотор талд хүчитгэсэн ус тусгаарлалт хийнэ. Хамгаалалтын гэр хоолойд хоолойг тавьж хоёр талыг битүүмжилэнэ. Бохир усны цоогийг дотор талаас нь ус тусгаарлалт хийж өгөх шаардлагатай.

Бохир усны хоолойн материал ба шугамын гидравлик тооцоо

Бохир усны хоолойн материалыг зөөлөн ширэм, шугамын диаметрыг 110-160мм-р авав. Бохир усны худагт улмай цутгамал кольцо ашиглана. Бохир усны шугамын тооцооны дүүргэлт, хамгийн бага хурдыг дараахь хүснэгтэнд үзүүлснээр авсан. Үүнд:

Диаметр,мм	Дүүргэлт,h/d	Хамгийн бага хурд,м/с
110-160	0.60	0.70

УС ХАНГАМЖ:

Тус барилгын цэвэр ус нь өөрийн ус дулаан бэлтгэх төвөөс баталгаат түрэлтээр хангагдана. Шугам хоолойг одоо байгаа трассын дагууд нь дулааны шугамтай хамт барилга руу оруулахаар төлөвлөв. ДХ-1-т гадна галын гидрант төлөвлөж өгөв. ДХ-1, ДХ1-ээс сургуулийн барилга хүртлэх сувагт явах халуун усны өгөх буцах шугам, хүйтэн шугам хоолой болон сувгийг шинэчлэхээр материалын түүвэрт тусгав. Суваг болон шугам хоолойг угсрахдаа ус тусгаарлалтын сайтар хийж өгөхийг анхаарна уу. Усан сангийн өрөөний дотор хана таазыг засварлах ажлыг материалын түүвэрт тусгав.

Шугам хоолой, холбох хэрэгсэл:

Гадна ус хангамжийн шугам сүлжээнд Ф25-50мм-ийн ГОСТ 3262-75 маркийн цайрдсан ган хоолой тавина. Шугам хоолойг 50мм-ийн зузаантай пенополиуретан дулаалгаар дулаалж дулааны шугамтай хамт тавих ба гадуур нь ус тусгаарлагч хийж өгнө. Хоолойн даралт даах чадвар нь PN=1,0МПа.

Шугам сүлжээнд MNS, ГОСТ, EN, ISO стандартын шаардлага хангасан, PN=1,0МПа даралт даах чадвартай задрах холбоос бүхий хаалт арматур болон бусад холбох хэрэгсэл ашиглана.

Төлөвлөж буй ариутгах татуургын шугамын ихэнхи хэсэг нь хөрсний усны түвшин өндөртэй газарт тавихаар төлөвлөгдсөн тул газар шорооны болон угсралтын ажлын үед зурагт тусгасан заавар, зөвлөмжийг чанд баримтлан ажиллах шаардлагатай.

Гадна бохир усны шугамын барилга-угсралтын ажлын үед анхаарах зүйлүүд:

Ариутгах татуургын шугам нь хөрсний усны түвшин өндөртэй /1.8-2.0 метр/ газарт таарч байгаа тул энэ хэсгийн шугамын материалд дараах үзүүлэлттэй ширмэн хоолойг сонгоно. Үүнд:
Шугамын материал резинэн нягтруулагчтай, дотор тал нь элс-цементэн өнгөлгөөтэй гадна тал нь хар тосон битум түрхлэгтэй ширмэн хоолой /ISO2531 & EN545 Ductile Iron Pipe/ байна. Шугамын диаметр 110-160мм.

Төлөвлөж байгаа бохир усны шугамын барилга-угсралтын ажлыг гүйцэтгэхдээ тухайн нөхцөл байдалд тохирсон технологи, арга, ажиллагаа, цаг хугацааг зөв сонгох, хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагааг чанд мөрдөж хийх шаардлагатай .

Гадна бохир усны шугамыг барьж байгуулахдаа доор дурдсан технологийг анхаарч, барилга-угсралтын ажилд баримтлахыг зөвлөж байна. Үүнд :

- Хөрсний усны түвшин хамгийн бага байх үеийг сонгож газар шорооны ажлыг хийх шаардлагтай бөгөөд худагт гадна, дотор ус тусгаарлалтыг зурагт заасан зөвлөмж, аргачлалын дагуу зайлшгүй хийвэл зохино. Худагт *гадна, дотор ус тусгаарлалтыг* хэр зэрэг чанартай хийснээс шугамын цаашдын ашиглалт хамаарна.
- Траншейны өргөн нь ул хэсгээрээ хоолойн гадна диаметрээс 0.4м-с багагүй хэмжээгээр их байна.
- Траншейг налуу ухах боломж муутай газарт ялангуяа зай багатай давчуу хэсэгт түүний хоёр ханыг заавал бэхэлгээтэй ухаж, ухлагаас гарсан шороог самосвалд ачиж, зөөвөрлөж өөр газарт түр асгах, хоолойг угсарсан хэсгийг, худгаас худгийн хооронд хэсэгчлэн шалгаж буцаан булах аргаар гүйцэтгэнэ.
- Хоолойг угсрахдаа траншейны ёроолд 0.15м-н зузаантай элсэн дэвсгэр хийж өгөх ба зурагт заасны дагуу сайтар нягтруулж өгнө. Буцаан булж байгаа хөрсийг үелүүлэн тарааж бага оврын механикжсан нягтруулагчаар нягтруулна.
- Автозам доогуур гарах, түүнийг буцаан сэргээх ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх хэрэгтэй.
- Газар шорооны ажлыг эхлэхээс өмнө трассын дагуу ил ба далд орших инженерийн шугам, сүлжээний байршлыг дахин тодруулж, холбогдох газруудаас зөвшөөрөл авч, барилгын ажлын үед хариуцсан мэргэжилтнүүдийг байлцуулах шаардлагатай.
- Төлөвлөж байгаа шугамууд нь холбоо, цахилгаан, дулаан, үерийн болон цэвэр усны шугамтай огтлолцож байгаа тул ийм орчинд шугам хоолойг угсрахдаа кабель шугамуудыг мэргэжлийн байгууллагаар ухаж гаргуулан хамгаалалт хийлгүүлсний дараа траншейг ухах, бэхлэх, хоолойг угсрах, буцааж булах, нягтруулах, кабель шугамуудыг хэвийн байдалд нь байрлуулж, булж нягтруулах ажлуудыг зэрэг хийхээр ажлыг зохион байгуулах хэрэгтэй.
- Барилга-угсралтын ажлын үед ямар нэг байдлаар хөндөгдсөн газар доорхи ба дээрхи инженерийн шугам, сүлжээ, тэдгээрийн барилга, байгууламжийг холбогдох байгууллагуудад актаар хүлээлгэн өгнө.
- Трассын улаан шугам, тэг тэнхлэгийг тавих үед шийдэх асуудал гарвал захиалагч болон бусад холбогдох байгууллагууд, зохиогч хамтран шийдвэрлэнэ.
- Барилга-угсралтын ажлыг технологийн дагуу хийхийн тулд тухайн байгууллага нь зохих инженер-техникийн ажилтан, ажилчидтай, шаардлагатай машин, механизм, тоног төхөөрөмжтэй байх ёстой.
- Хөрсний усны түвшинг доошлуулах арга хэмжээг гүйцэтгэгч байгууллага ажил гүйцэтгэх төсөлөө хийж, түүний дагжж гүйцэтгэнэ.
- Гадна ариутгах татуургын шугам сүлжээний барилга-угсралтын ажлыг БНбД 40-04-16 "Ус хангамж, ариутгах татуургын гадна сүлжээ, барилга,байгууламж" -г баримтлан гүйцэтгэнэ.

ИНЖЕНЕР ГЕОЛОГИЙН ДҮГНЭЛТ "ГУРВАН ТЭС" ХХК-ИЙН БОЛОВСРУУЛСАН

1. Инженер геологийн судалгааны тайлангаас үзвэл тус талбай нь инженер геологийн энгийн нөхцөлтэй болно
2. Судалгааны талбайд ул хөрсний ус 1.8м-т илэрч 2,0м-т тогтсон гадаргуугийн угаагдал явагдах нөхцөлтэй
3. Хөлдөлтийн гүн

Хайргархаг шавранцар хөрс -2,46м
Шавранцараар чигжигдсэн сайрган хөрс -3,51м

Газар хөдлөлийн балл-7 баллын бүсэд байрлана.

ОЧИР ОГТЛОГЧ БИДНИЙ ТУРШЛАГА ТАНД ТУСАЛНА	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 23-р хороо 140 ДУГААР СУРГУУЛИЙН ХАЛУУН ХҮЙТЭН УС БОЛОН БОХИР УСНЫ ШУГАМАНД ХИЙГДЭХ ЗАСВАРЫН АЖИЛ		
	Ерөнхий тайлбар		Үе шат: ажлын зураг
ИНЖЕНЕР	Б.ИЖИЛЧИМЭГ	ЕГ Шифр: 00-13/2408-06	Масштаб:
ГҮЙЦЭТГЭСЭН	Б.БИЛГҮҮН		Огноо: 2024
"ОЧИР ОГТЛОГЧ" ХХК / ШАЛГАСАН	Б.ИЖИЛЧИМЭГ	ТГ Шифр: -	Зургийн дугаар: УХАТ-03 / Хуудас: 12

МОНГОЛ УЛС 20-3697 Буянжаргалын ИЖИЛЧИМЭГ МЭРГЭШСЭН ИНЖЕНЕР ЗТ-УХАТ 2022-2025

A3

Ус хангамж, ариутгах татуургын худагт ус тусгаарлалт хийх

Хөрсний устай нөхцөлд тавигдахаар төлөвлөж буй ус хангамж,ариутгах татуургын худагт ус тусгаарлах арга хэмжээг зайлшгүй авч хэрэгжүүлнэ. Үүнд :

- Гадаргууг бэлтгэх

Худгийн хана, ул, хүзүүвчийн цагирагийн гадаргад наалдсан шороо тоос, зуурмаг болон будаг бусад бүх зүйлсийг шүүрдэх, үрэх, шахсан агаараар үлээлгэх мөн даралттай элсээр шүрших аргаар цэвэрлэнэ. Хэрэв гадаргын ан цав байвал түүнийг цементэн зуурмагаар дүүргэж өнгөлнө. Гадаргуу хичнээн хуурай байна, тусгаарлалтын наалдац төдий чинээ сайн болж өгдөг. Иймээс ус тусгаарлах гадаргууг цас, бороонoос хучиж хамгаалах хэрэв чийг авсан бол халааж хатаах нь зүйтэй.

- Будагт ус тусгаарлалт

Энэ нь битум буюу нийлэг түрхлэгээр гадаргад олон үе будаж хийх тусгаарлалт болно. Битумийг халуун ба хүйтэн байдлаар түрхэж ус тусгаарлалт хийнэ. Ус тусгаарлах будалтаас өмнө хөрсжүүлэг тавина. Битумээр тусгаарлахад битумийн, нийлэг хөрсжүүлэгэнд нийлэг гаралтай холбогч бүхий шингэн түрхлэг хэрэглэх ёстой. Ус тусгаарлах ажлыг маш нарийн гүйцэтгэх шаардлагатай. Түрхлэгийг 2-3 удаа будаж 0.4мм хүртэл зузаарууж өгөх хэрэгтэй.

- Наамал ус тусгаарлалт

Түрхлэг хийх аргаар ус тусгаарлах арга тохиромжгүй тохиолдолд дараагийн арга хэмжээ болгож наах аргыг хэрэглэж болно. Ус ул нэвтрүүлэх хуйлмал материал болон ширхэгийн материалыг нийлэг түрхлэгээр гадаргад нааж илүү сайн ус тусгаарлалт хийх хэрэгтэй. Наамал ус тусгаарлалтын өмнө гадаргыг хөрсжүүлнэ. Зарим нэг бэлтгэл ажил тухайлбал хэвтээгээс босоо чиглэлд тусгаарлалт шилжвэл тэр уулзварт хуйлмал материалаар нэмж давхарлаж наах хэрэгтэй. Тусгаарлалтыг олон үе хийхээр бол дагуу ба хөндлөн чиглэлд үелүүлэн наах хэрэгтэй.

- Шавардага хийж ус тусгаарлалт хийх

Цемент элсэн зуурмаг ба асфальтбетон буюу асфальт түрхлэг хэрэглэж гүйцэтгэдэг. Тэлдэг цемент болон ул агших цемент энд тохиромжтой. Тусгаарлалтын зузаан 5-40 мм байж болно. Асфальтан бетонд тусгаарлалтыг халуун ба хүйтэн лав хэрэглэж 20-35мм зузаан гүйцэтгэнэ.

- Ус чийг тусгаарлах материалууд:

1. Хуйлмал хуванцар (полиэтилэн) материалууд, шил, төмрийн төрлийн материалууд, хар давирхай (хар тос), хар цаас, ус тусгаарлагч түрхлэг болон өнгөлгөөний зуурмаг.
2. Пенетроны төрлийн материалууд: Акватрон, пенекрит, пенетрон-адмикс, пенедлаг, пенетрон плюс материал. Пенетрон гэдэг нь олон давхаргат бетонон болон төмөрбетон бүтээцийг уснаас тусгаарлахад зориулсан материалыг хэлнэ.

Ус тусгаарлалт хийх аргачлал :

Ус тусгаарлалтыг дотор ба гадна гэж ангилана. Ус тусгаарлалтын ажлыг гадна агаарын хэм +5°С-с багагүй үед гүйцэтгэнэ.

Гадна ус тусгаарлалтыг худгийн дээд ирмэг хүртэл хийж өгнө.Ингэхдээ дээр дурдсан дараалын дагуу гүйцэтгэнэ. Үүнд :

1. гадаргууг бэлтгэх
2. будагт ус тусгаарлалт
3. наамал ус тусгаарлалт
4. шавардлагат ус тусгаарлалт

Худгийн улны ус тусгаарлалтыг шингэрүүлсэн битумээр хөрсжүүлэлт хийж, халуун асфальт 10мм-ийн зузаантайгаар түрхэж хийнэ.

Худгийн хана, ховил, хучилтын гадна ус тусгаарлалтыг хийхдээ бензинд уусгасан битумээр 4-5мм-ийн зузаантай хөрсжүүлэлт хийж хоёроос доошгүй үе халуун битумээр будаж хийнэ .

Дээр дурдсан ус тусгаарлалт нь худгийн гадна ус тусгаарлалтанд хамаарна. Худгийн дотор ус тусгаарлалтыг заавал гүйцэтгэх шаардлагатай. Дотор ус тусгаарлалтын аргачлал нь гадна ус тусгаарлалттай адил. Дотор ус тусгаарлалтанд хэрэглэх хамгийн найдвартай, сайн арга нь "Пенетрон+Пенекрит"-г хэрэглэх арга юм.

Худгийн хийцийн ховил, заадас, уулзвар, шугам хоолойн оролт, гаралтын хэсгээр ус тусгаарлалт хийх зорилгоор «ПЕНЕКРИТ» ба «ПЕНЕБАР» материалыг ашиглан ус тусгаарлах ажлыг гүйцэтгэнэ. Ан цавын ус тусгаарлалтыг зөвхөн «ПЕНЕКРИТ»-ээр гүйцэтгэнэ.

Ус тусгаарлалт хийх гэж байгаа гадаргууг эхлээд цэвэрлэж бэлтгэнэ. Ингэхдээ төмөр сойз, даралттай усаар шүршиж цэвэрлэж болно. Ус тусгаарлалт хийх шаардлагатай ховилт заадсыг норгож чийглээд (багс, даралттай усаар) «ПЕНЕТРОН» -ны нэгдүгээр үеийг түрхэж хөрсжүүлэлт хийнэ.

Ховилт заадсын хэмжээ 25x25мм-т «ПЕНЕТРОН»-ы орцыг 0.1кг/у.м гэж тооцно. Бэлтгэсэн ховилт заадсыг «ПЕНЕКРИТ»-н зуурмагаар нягт чигжиж дүүргэнэ. Нэг удаа түрхэж байгаа «ПЕНЕКРИТ»-н зуурмагын зузаан нь 30мм-с илүүгүй байна.

Хэрэв ховилт заадас их гүн байвал «ПЕНЕКРИТ»-н зуурмагыг хэд хэдэн удаагийн түрхэлтээр хийнэ. 30x30мм-с илүү хэмжээтэй ховилт заадсыг бөглөхдөө «ПЕНЕКРИТ»-н орцыг хэмнэхийн тулд «ПЕНЕКРИТ»-н зуурмагт эзэлхүүний нь 50 хүртэлхи хувьд жижиг ширхэгтэй угаасан хайрга (фракцийн хэмжээ нь 5-10мм) хольж хийж болно. «ПЕНЕКРИТ»-н зуурмагаар чигжиж дүүргэсэн ховил болон ойролцоох гадаргыг норгож чийглээд хоёр үе «ПЕНЕТРОН» түрхэж өгнө.

ОЧИР ОГТЛОГЧ БИДНИЙ ТУРШЛАГА ТАНД ТУСАЛНА	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 23-р хороо 140 ДУГААР СУРГУУЛИЙН ХАЛУУН ХҮЙТЭН УС БОЛОН БОХИР УСНЫ ШУГАМАНД ХИЙГДЭХ ЗАСВАРЫН АЖИЛ			
	Ус хангамж, ариутгах татуургын худагт ус тусгаарлалт хийх			Үе шат: ажлын зураг
	ИНЖЕНЕР	Б.ИЖИЛЧИМЭГ	ЕГ Шифр: 00-13/2408-06	Масштаб:	Огноо: 2024
	ГҮЙЦЭТГЭСЭН	Б.БИЛГҮҮН			
"ОЧИР ОГТЛОГЧ" ХХК	ШАЛГАСАН	Б.ИЖИЛЧИМЭГ	ТГ Шифр: -	Зургийн дугаар: УХАТ-04	Хуудас: 12

МОНГОЛ УЛС 20-3697 АТХ8369 Бүрэнжаргалын ИЖИЛЧИМЭГ МЭРГЭШСЭН ИНЖЕНЕР ЗТ-УХАТ 2022-2025

A3

Худгийн хананд ус тусгаарлалт хийх



Худгийн хучилтанд ус тусгаарлалт хийх

ДОТОР ТАЛААС НЬ



ГАДНА ТАЛААС НЬ



Худгийн цутгамал бетон шаланд ус тусгаарлалт хийх



ОЧИР ОГТЛОГЧ БИДНИЙ ТУРШЛАГА ТАНД ТУСАЛНА "ОЧИР ОГТЛОГЧ" ХХК	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 23-р хороо 140 ДУГААР СУРГУУЛИЙН ХАЛУУН ХӨЙТЭН УС БОЛОН БОХИР УСНЫ ШУГАМАНД ХИЙГДЭХ ЗАСВАРЫН АЖИЛ				
	Ус хангамж, ариутгах татуургын худагт ус тусгаарлалт хийх				Үе шат: ажлын зураг
ИНЖЕНЕР	Б.ИЖИЛЧИМЭГ	ЕГ Шифр: 00-13/2408-06	Масштаб:	Огноо: 2024	
ГҮЙЦЭТГЭСЭН	Б.ВИЛГҮҮН				
ШАЛГАСАН	Б.ИЖИЛЧИМЭГ	ТГ Шифр: -	Зургийн дугаар: УХАТ-05	Хуудас: 12	

МОНГОЛ УЛС 20-3697 АТХ8369 Буянжаргалын ИЖИЛЧИМЭГ мэргэшсэн инженер ЗТ-УХАТ 2022-2025

А3

ГАДНА АРИУТГАХ ТАТУУРГЫН ШУГАМЫН ДАГУУГИЙН ЗҮСЭЛТ



Хэвтээ масштаб М1:500
Босоо масштаб М:100





Хоолойн ёроолын тэмдэгт	1521.14	1521.01	1520.96	1520.82	1520.68	1520.62	1520.60	1520.97	1520.84	1520.68
Газрын хөрсний төслийн тэмдэгт	1522.85	1522.60	1522.80	1523.10	1522.60	1522.50	1523.00	1523.10		
Газрын хөрсний одоогийн тэмдэгт	1522.50	1522.00	1522.00	1522.62	1522.30	1522.30	1523.00	1522.62		
Хоолойн материал		Ф110	Элс цементэн доторлогоотой, гадуураа хар тосон битүмэн түрхлэгтэй, резинэн цагирагтай ширмэн хоолой, Ø170x6.3мм, ISO25318 & EN545						Ф110	
Буурь		Байгалийн хөрс, элсэн дэвсгэр 10см								
Урт / Хэвгий		0.02 / 6.5	0.008 / 17.8	0.008 / 17.8	0.008 / 7.9	0.008 / 3.0			0.02 / 6.5	
Хоорондын зай		6.5м	46.5м						6.5м	
Онцлох цэг, худаг эргэлтийн дугаар		Бар БУХ-1 90°	БУХ-2	БУХ-3	БУХ-4		Одоо байгаа цооног W=40.0м³		Бар БУХ-3	

Тайлбар

- Ариутгах татуургын шугамын байгууламжтыг УХАТ-02 хуудаснаас үзнэ үү.
- Сувгийн хөндлөн огтлол 1-1, 2-2 -ыг УХАТ-09 хуудаснаас үзнэ үү.

ОЧИР ОГТЛОГЧ
БИДНИЙ ТУРШЛАГА ТАНД ТУСАЛНА
"ОЧИР ОГТЛОГЧ" ХХК

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 23-р хороо
140 ДУГААР СУРГУУЛИЙН ХАЛУУН ХҮЙТЭН УС БОЛОН БОХИР УСНЫ ШУГАМАНД ХИЙГДЭХ ЗАСВАРЫН АЖИЛ

Гадна ариутгах татуургын шугамын дагуугийн зүсэлт

Үе шат: ажлын зураг

ИНЖЕНЕР	Б.ИЖИЛЧИМЭГ	ЕГ Шифр:	Масштаб:	Огноо:
ГҮЙЦЭТГЭСЭН	Б.БИЛГҮҮН	ОО-13/2408-06		2024
ШАЛГАСАН	Б.ИЖИЛЧИМЭГ	ТГ Шифр:	Зургийн дугаар:	Хуудас:
		-	УХАТ-06	12

МОНГОЛ УЛС Б.ИЖИЛЧИМЭГ МЭРГЭШСЭН ИНЖЕНЕР зт-ухаа 2022-2025

А3

ЛОТОКИЙН СХЕМ

СХЕМ I



СХЕМ II



СХЕМ III



ОГТЛОЛ 1-1



БОХИР УСНЫ ТӨМӨР БЕТОН ХУДГИЙН ОГТЛОЛ



МОДОН ТАГНЫ БАЙГУУЛАЛТ, М1:10



ОГТЛОЛ 2-2



ОЧИР ОГТЛОГЧ ББСУГ	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 23-р хороо 140 ДУГААР СУРГУУЛИЙН ХАЛУУН ХҮЙТЭН УС БОЛОН БОХИР УСНЫ ШУГАМАНД ХИЙГДЭХ ЗАСВАРЫН АЖИЛ				
	Бохир усны худгийн огтлол ба лотокийн схем				Үе шат: ажлын зураг
ИНЖЕНЕР	Б.ИЖИЛЧИМЭГ	ЕГ Шифр: ОО-13/2408-06	Масштаб:	Огноо: 2024	
ГҮЙЦЭТГЭСЭН	Б.БИЛГҮҮН				
"ОЧИР ОГТЛОГЧ" ХХК	ШАЛГАСАН Б.ИЖИЛЧИМЭГ	ТГ Шифр: -	Зургийн дугаар: УХАТ-07	Хуудас: 12	

МОНГОЛ УЛС 20-3697 АТХ8369 Буянжаргалын ИЖИЛЧИМЭГ Мэргэшсэн инженер эт-ухат 2022-2025

А3

БЭХЭЛГЭЭНИЙ ДЕТАЛЬ, М1:10

МС 1.2.3.4



МС 5.6.7.8



ОГТЛОЛ А-А



ОГТЛОЛ Б-Б



Жин, кг

Марк	№ поз	Дүүргэлт	Урт, мм	Тоо			
					поз	В сех поз	Марк
1	2	3	4	5	6	7	8
МС-1 D=700	1	80х8	160	2	0.80	1.60	2.05
	2	80х8	90	1	0.45	0.45	
МС-2 D=1000	1	80х8	160	2	0.80	1.60	2.10
	3	80х8	100	1	0.50	0.50	
МС-3 D=1500	1	80х8	160	2	0.80	1.60	2.15
	4	80х8	110	1	0.55	0.55	
МС-4 D=2000	1	80х8	160	2	0.80	1.60	2.20
	5	80х8	120	1	0.60	0.60	
МС-5 D=700	1	80х8	160	1	0.80	0.80	1.65
	6	80х8	170	1	0.85	0.85	
МС-6 D=1000	1	80х8	160	1	0.80	0.80	1.70
	7	80х8	180	1	0.90	0.90	
МС-7 D=1500	1	80х8	160	1	0.80	0.80	1.75
	8	80х8	190	1	0.95	0.95	
МС-8 D=2000	1	80х8	160	1	0.80	0.80	1.80
	9	80х8	200	1	1.00	1.00	

ОГТЛОЛ В-В



ГИШГҮҮР



ГИШГҮҮР ШАТ



ОГТЛОЛ Г-Г



ТАЙЛБАР

- Зэврэлтээс хамгаалах түрхлэг түрхэх
- "В" хэмжээс цагирагны хананы зузаантай тэнцүү байна.
- Бэхэлгээний детальд ГОСТ 380-2005 стандартын ган ашиглана. Гангийн марк 8сп3кл2, эсэргүүцэл R=2100 кг/см.

ОЧИР ОГТЛОГЧ ББСУТ	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 23-р хороо 140 ДУГААР СУРГУУЛИЙН ХАЛУУН ХҮЙТЭН ЦС БОЛОН БОХИР УСНЫ ШУГАМАНД ХИЙГДЭХ ЗАСВАРЫН АЖИЛ				
	Бэхэлгээний детальд, ашигүүр шат				Үе шат: ажлын зураг
ИНЖЕНЕР	Б.ИЖИЛЧИМЭГ		ЕГ Шифр: 00-13/2408-06	Масштаб:	Огноо: 2024
ГҮЙЦЭТГЭСЭН	Б.БИЛГҮҮН				
"ОЧИР ОГТЛОГЧ" ХХК	ШАЛГАСАН	Б.ИЖИЛЧИМЭГ	ТГ Шифр: -	Зургийн дугаар: УХАТ-08	Хуудас: 12

МОНГОЛ УЛС 20-3697 АТЛАХ Буянжаргалын ИЖИЛЧИМЭГ МЭРГЭШСЭН ИНЖЕНЕР ЗТ-УХА-2022-2022

А3

БОХИР УСНЫ ХУДГИЙН ТӨМӨР БЕТОН ХИЙЦИЙН ТҮҮВЭР

Худгийн дугаар	Худгийн марк	Нэг маягийн эдгээр дугаар	Худгийн бүрэн өндөр H1 /м/	Худгийн диаметр /мм/	Ховилын тоймын дугаар	Ховилын бетоны эзлэхүүн /м3/	Ёроолын хавтангийн зузаан /мм/	Ховилын гүн /мм/	Худгийн ажлын хэгээйн өндөр Hр /см/	Хучилтын хавтангийн зузаан /мм/	Хүзүүвчийн өндөр hг /см/	Ажлын хэсэг /ш/										Хүзүүвч /ш/						Бэхэлгээний деталь /ш/				Шатны гишгүүр /ш/	Ус тусгаарлагч хийх талбай, м2	Чигжээс бетон эзлэхүүн /м3/	Дүн
												ул хавтан /ш/																						
												ПД10-1-1	КС10 h=600	КС10 h=890	ПП10-1-2	ПД15-1-1	КС15h=600	КС15 h=890	ПП15-1-2	КС20 h=890	ПП20-1-2	КС7 h=890	КС7 h=600	КС7 h=500	КС7 h=300	КО h=70	чигжээс бетоны өндөр М200 /мм/	МС-1	МС-2	МС-5	МС-6				
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31	32	33	34	35	36
БУХ-1	I	22	1640	1000	II	0.36	100	200	1200	150	90	1	2		1											1	90		4	4	8	3	6.19	0.05	118.874
БУХ-2	I	1	1980	1000	I	0.36	100	200	1500	150	130	1	1	1	1											1	130		4	4	8	4	7.28	0.08	161.122
БУХ-3	I	36а	2420	1000	III	0.35	100	200	1500	150	570	1	1	1	1									1		1	70		4	8	8	5	7.28	0.04	107.554
БУХ-4	I	1	1980	1000	I	0.36	100	200	1500	150	130	1	1	1	1											1	130		4	4	8	4	7.28	0.08	161.122
Дүн												4	5	3	4	0	0	0	0	0	0	0	0	1	0	4	420	0	16	20	32	15	28.03	0.24	548.67
Бетоны орц /м3/												0	1.4	0.6	0.275	0.21	0.7	1.05	0.7	1.475	0.7	0.375	0.25	0.125	0.125	0.05									
Нийт бетон /м3/						1.43						0	7	1.8	1.1	0	0	0	0	0	0	0	0	0.125	0	0.2									10.225
Төмрийн орц /кг/												0	3.5	3.8	14.9	10.2	3.75	5.7	22.35	7.6	29.8	0.9	0.9	2.8	2.8	1.2		2.05	2.1	1.65	1.7	0.9			
Нийт төмрийн орц /кг/												0	17.5	11.4	59.6	0	0	0	0	0	0	0	0	2.8	0	4.8		0	33.6	33	54.4	13.86			230.96

СУВГИЙН ХӨНДЛӨН ОГТЛОЛ 1-1



СУВГИЙН ХӨНДЛӨН ОГТЛОЛ 2-2



ОЧИР ОГТЛОГЧ ББСИЙН ТУРШЛАГА ТАНД ТУСАЛНА	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 23-р хороо 140 ДУГААР СУРГУУЛИЙН ХАЛУУН ХҮЙТЭН УС БОЛОН БОХИР УСНЫ ШУГАМАНД ХИЙГДЭХ ЗАСВАРЫН АЖИЛ				
	БУХ-ийн төмөр бетон хийцийн түүвэр				Ye шат: ажлын зураг
ИНЖЕНЕР	Б.ИЖИЛЧИМЭГ	ЕГ Шифр:	ОО-13/2408-06	Масштаб:	Огноо: 2024
ГҮЙЦЭТГЭСЭН	Б.БИЛГҮҮН	ТГ Шифр:	-	Зургийн дугаар: УХАТ-09	Хуудас: 12
"ОЧИР ОГТЛОГЧ" ХХК	ШАЛГАСАН Б.ИЖИЛЧИМЭГ				

МОНГОЛ УЛС 20-3697 АТХ8369 Буянжаргалын ИЖИЛЧИМЭГ МЭРГЭШСЭН ИНЖЕНЕР ЗТ-УХАТ 2022-2025

ГАДНА УС ХАНГАМЖИЙН ШУГАМЫН УГСРАЛТЫН ТОЙМ



ТАНИХ ТЭМДЭГ:

- Галын гидрант
- Фланцтай хаалт
- Ус юүлэгч
- Шилжвэр

ОЧИР ОГТЛОГЧ БИДНИЙ ТУРШЛАГА ТАНД ТУСАЛНА	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 23-р хороо 140 ДУГААР СУРГУУЛИЙН ХАЛУУН ХҮЙТЭН УС БОЛОН БОХИР УСНЫ ШУГАМАНД ХИЙГДЭХ ЗАСВАРЫН АЖИЛ				
	Гадна ус хангамжийн шугамын угсралтын тойм				Үе шат: ажлын зураг
ИНЖЕНЕР	Б.ИЖИЛЧИМЭГ	ЕГ Шифр: ОО-13/2408-06	Масштаб:	Огноо: 2024	
ГҮЙЦЭТГЭСЭН	Б.БИМРЭГТ				
"ОЧИР ОГТЛОГЧ" ХХК	ШАЛГАСАН	Б.ИЖИЛЧИМЭГ	ТГ Шифр: -	Зургийн дугаар: УХАТ-10	Хуудас: 12

МОНГОЛ УЛС 20-3697 АТХ8369 Бүхнэжаргалын ИЖИЛЧИМЭГ ЗӨВШӨӨРӨГДСӨН ИНЖЕНЕР эт.ухат. 2022-2027

Зураг тасалд магадлан сийлэв 6-13 2024 09 10 Засвартай эсэх БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР

ШИНЭЧИЛСЭН ДУДААНЫ ХУДГИЙН БАЙГУУЛАЛТ /ДХ-1/, М1:40



ШИНЭЧИЛСЭН ДУЛААНЫ ХУДГИЙН ОГТЛОЛ 1-1 /ДХ-1/, М1:40



ХУДГИЙН МАТЕРИАЛЫН ТҮҮВЭР

Худгийн төрөл	Хучилтын элемент		Материалын орц		
	Марк	Тоо ширхэг	Хана /м³/	Таг /ш/	Ниш /м³/
ТК-10 /Цутгамал бетон/	П-1	3	19.0 м³ бетон	4ш ширэм	1.5м³ цул бетон
	П1а	1			
	П-4	2			
	П4а	2			
	По3	4			
	Б-2	2			

ОЧИР ОГТЛОГЧ БИДНИЙ ТУРШЛАГА ТАНД ТУСАЛНА	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 23-р хороо 140 ДУГААР СУРГУУЛИЙН ХАЛУУН ХҮЙТЭН УС БОЛОН БОХИР УСНЫ ШУГАМАНД ХИЙГДЭХ ЗАСВАРЫН АЖИЛ					
	Шинэчилсэн дулааны худгийн байгуулалт, огтлол /ДХ-1/					Үе шат: ажлын зураг
ИНЖЕНЕР	Б.ИЖИЛЧИМЭГ		ЕГ Шифр:	Масштаб:	Огноо:	
ГҮЙЦЭТГЭСЭН	Б.БИЛГҮҮН		ОО-13/2408-06	М1:40	2024	
ШАЛГАСАН	Б.ИЖИЛЧИМЭГ		ТГ Шифр: -	Зургийн дугаар: УХАТ-11	Хуудас: 12	
"ОЧИР ОГТЛОГЧ" ХХК						

МОНГОЛ УЛС Буянжаргалын ИЖИЛЧИМЭГ МЭРГЭШСЭН ИНЖЕНЕР зт-ухаа 2022-2024

А3

МАТЕРИАЛЫН ТҮҮҮВЭР

Д/д	Тэмдэглэгээ	Материалын түүвэр	Тоо шир	Нэгж жин	Тайлбар
		УС ХАНГАМЖ			
1	ГОСТ 3262-75	Ган хоолой, Ф32х2.5	70.0	-	у/м
2	ГОСТ 3262-75	Ган хоолой, Ф38х2.5	70.0	-	у/м
3	ГОСТ 3262-75	Ган хоолой, Ф57х3.0	70.0	-	у/м
4	Пинополиуретан	Хоолойн дулаалга Ф25, Δ50мм	70.0	-	у/м
5	Пинополиуретан	Хоолойн дулаалга Ф32, Δ50мм	70.0	-	у/м
6	Пинополиуретан	Хоолойн дулаалга Ф50, Δ50мм	70.0	-	у/м
7	MNS ISO	Хаалт Ф25, PN=1.0 МПа	1	-	ш
8	MNS ISO	Хаалт Ф32, PN=1.0 МПа	1	-	ш
9	MNS ISO	Фланцтай ган хаалт Ф50, PN=1.0 МПа	1	-	ш
10	ГОСТ 12820-80	Ган фланц Ф50, PN=1.0 МПа	2	-	ш
11	ГОСТ 9544-2015	Ус буулгагч, Ф25	3	-	ш
12		Отвод, Ф25	3	-	ш
13		Отвод, Ф32	3	-	ш
14		Отвод, Ф50	3	-	ш
15	Шилэн хөвөн	Тоноглолын дулаалга Dy100 Tmax200°C p=150кг/м3 q=0.045вт/м	1.5	-	м²
16		Гулсах тулгуур ГТ 17.10-25	41	-	ш
17		Гулсах тулгуур ГТ 17.10-32	35	-	ш
18		Гулсах тулгуур ГТ 17.10-50	23	-	ш
19		Бетон дэр ОП-1 /200х200х90/	99	-	ш
20		Галын гидрант Ф100 h=100мм	1	-	ш
21		Суурьтай гуравлагч Ф100х100х100	1	-	ш
22		Шилжвэр Ф100/50	2	-	ш
23		Бетон дэр /300х400х400h/	1	-	ш
24	MNS 3875: 1986	Цутгамал суваг /1400х385/	70.0	-	м
25		Хучилтын төмөр бетон хавтан 1600х500х120	140	-	ш
26		4000х3500х2000h хэмжээтэй бетон худаг, ТИП ТК-10	1	-	ком
27		Ширмэн таг, Ф700	4	-	ш
28		Усан сангийн өрөөний таазыг эмульсдэх	135.0	-	м²
29		Усан сангийн өрөөний дотор хана будах	260.0	-	м²

МАТЕРИАЛЫН ТҮҮҮВЭР

Д/д	Тэмдэглэгээ	Материалын түүвэр	Тоо шир	Нэгж жин	Тайлбар
		АРИУТГАХ ТАТУУРГА			
1	Пенополиуретан дулаалга, δ=50мм	Дулаалга Ф100, DN10	15.0	-	у/м
2	Пенополиуретан дулаалга, δ=50мм	Дулаалга Ф160, DN10	50.0	-	у/м
3	ISO25318 & EN545, Ductile iron pipe	Элс цементэн доторлогоотой, гадуураа хар тосон битүмэн түрхлэгтэй, резинэн цагирагтай ширмэн хоолой, Ф118х6.0мм	15.0	18.4	у/м
4	ISO25318 & EN545, Ductile iron pipe	Элс цементэн доторлогоотой, гадуураа хар тосон битүмэн түрхлэгтэй, резинэн цагирагтай ширмэн хоолой, Ф170х6.3мм	50.0	22.8	у/м
5		Нягтруулагч резинэн цагираг, гадуураа хар томон битумэн түрхлэгтэй, резинэн цагирагтай ширмэн хоолой, Ф118х6.0мм	3	0.28	ш
6		Нягтруулагч резинэн цагираг, гадуураа хар томон битумэн түрхлэгтэй, резинэн цагирагтай ширмэн хоолой, Ф170х6.3мм	8	0.36	ш
7	Угсармал төмөр бетон худаг	Төмөр бетон худаг Ф1000	4	-	ш
8	ГОСТ 3634-99	Ширмэн таг ба амсар Ф700	4	65.0	ш
9		Дулаалгатай модон таг Ф630	4	2.6	ш
10		Ган бүрхэвч Ф325х8.0	11.0	-	у/м
11	Пенетрон	Бохир усны цооногын ус тусгаарлагч түрхлэг	200.0	-	м²

Д/д	Тэмдэглэгээ	Материалын түүвэр	Тоо шир	Нэгж жин	Тайлбар
		АРИУТГАХ ТАТУУРГА, УС ХАНГАМЖ /Буулгах ажил/			
1		Бохир усны хуванцар хоолой Ф200	50.0	-	у/м
2		Бохир усны хуванцар хоолой Ф110	15.0	-	у/м
3		Төмөр бетон худаг Ф1000	4	-	ш
4		Хүйтэн усны цайрдсан ган хоолой Ф25	70.0	-	у/м
5		Хүйтэн усны цайрдсан ган хоолой Ф25	70.0	-	у/м
6		Хүйтэн усны цайрдсан ган хоолой Ф25	70.0	-	у/м
7		Цутгамал суваг /1400х385/	70.0	-	м
8		4000х3500х2000h хэмжээтэй бетон худаг, ТИП ТК-10	1	-	ком

ОЧИР ОГТЛОГЧ
БИДНИЙ ТУРШЛАГА ТАНД ТУСАЛНА
"ОЧИР ОГТЛОГЧ" ХХК

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 23-р хороо
140 ДУГААР СУРГУУЛИЙН ХАЛУУН ХҮЙТЭН УС БОЛОН БОХИР УСНЫ ШУГАМАНД ХИЙГДЭХ ЗАСВАРЫН АЖИЛ

Материалын түүвэр

ИНЖЕНЕР	Б.ИЖИЛЧИМЭГ	ЕГ Шифр: 00-13/2408-06	Масштаб:	Ye шат: ажлын зураг
ГҮЙЦЭТГЭСЭН	Б.БИЛГҮҮН	ТГ Шифр: -	Зургийн дугаар: УХАТ-12	Огноо: 2024
ШАЛГАСАН	Б.ИЖИЛЧИМЭГ			Хуудас: 12

МОНГОЛ УЛС 20-3697 АТХ8369 БУЯНКАРГАЛЫН ИЖИЛЧИМЭГ МЭРГЭШСЭН ИНЖЕНЕР 3Т-УХАТ 2022-2025

А3